

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 08 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2024 оны эхний хагас жил)

5.6 хувь

Валютын нөөц

(2024 оны 8 дугаар сар)

4,704 сая \$

Инфляц

(2024 оны 8 дугаар сар)

6.5 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны 8 дугаар сар)

1.6 их наяд ₮

Экспорт

(2024 оны 8 дугаар сар)

10.6 тэрбум \$

Импорт

(2024 оны 8 дугаар сар)

7.5 тэрбум \$

ГШХО

(2024 оны эхний хагас)

2,070 сая \$

Зээлийн хүү

(2024 оны 8 дугаар сар)

17.0 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 2 дугаар улирал)

1.3 сая

*11 улирлын байдлаар ажиллах хүчний орлогооны түвшин 62 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 оны 2 дугаар улирал)

23.6 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны 2 дугаар улирал)

99.1 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт


(2024 оны 2 дугаар улирал)

17.3 хувь



2024 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 5.6 хувь байна. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарын үйлдвэрлэл эерэг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Өмнөх оны өндөр суурийн нөлөөгөөр уул уурхайн салбарын оролцоо багасаж, үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
(2024 оны эхний хагас жил)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛУУРХАЙ
(бодит үйлдвэрлэлийн хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ
(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2024 оны эхний хагас жилд **5.6 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 15.4 хувиар тэлж өсөлтийн 1.8 хувийг, ХАА-н салбар 26.7 хувиар агшиж өсөлтийг -3.9 нэгж хувиар хязгаарлалаа.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 7.9 хувиар өсөж өсөлтийн 0.8 нэгж хувийг;
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 9.3 хувиар өсөж өсөлтийн 4.4 хувийг;
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 15.0 хувиар өсөж өсөлтийн 2.3 хувийг бүрдүүлсэн байна.

- Үйлчилгээний салбар болон цэвэр татварын орлого нэмэгдсэнээр өсөлтийн дийлэнхийг бүрдүүлж байна. Мөн боловсруулах, барилгын салбарын үйлдвэрлэл өсөлттэй байв.
- Харин том малын зүй бус хорогдол нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар агшив.


- Уул уурхайн салбар 2024 оны эхний хагас жилд 15.4 хувиар тэллээ.
- Газрын тос, молибдений баяжмал, алтны олборлолтоос бусад уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөллөө.

- ХАА-н салбар 2024 оны эхний хагас жилд 26.7 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 2024 оны 2 дүгээр улирлын байдлаар 8.1 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 сая толгой малаар нэмэгдлээ. Энэ нь оны эхний нийт малын 12.5 хувийг эзэлснээр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурч байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 8 сард 11 хувиар өсөв. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөлж байгаа бол хөнгөн болон хүнд үйлдвэрлэл боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байна.


НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ (гэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны эхний 8 сард 21.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 11 хувиар өслөө.
- Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 15 хувиар нэмэгдээд байна.
- Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2 хувиар нэмэгдэхэд ундааны үйлдвэрлэл нэмэгдсэн нь эергээр нөлөөлөв.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ (ҮҮИ-ээр засварласан бодит дүн, тэрбум төгрөг)



Эх сурвалж: ЭЭХЯ-ны тооцоолол, УСХ

- Тус салбарын бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) 2024 оны эхний 7 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 хувиар өсөөд байна. Үүнд:
 - Салбарын дийлэнхийг эзэлдэг уул уурхайн салбарын үйлдвэрлэл 8.4 хувиар өсөж, гол нөлөө үзүүлэв.
 - Харин алтын улмаас малын хорогдол нэмэгдэж, мах боловсруулах үйлдвэрлэл буурснаар нийт боловсруулах үйлдвэрлэл бодит дүнгээр буурсан үзүүлэлттэй байна.


УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ (Голлох бүтээгдэхүүнээр)

Өмнөх өнөөс өөрчлөлт:	2024	2023
Нүүрс	64 сая тонн	32%
Зэсийн баяжмал	967 мян тонн	21%
Газрын тос	2.8 сая баррель	-15%
Алт	8.2 тонн	-13%
Төмрийн хүдэр	6.3 сая тонн	37%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нүүрс олборлолт 2024 оны эхний 8 сард 64 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 32 хувиар нэмэгдээд байна.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс сэргэж 37 хувиар өсөв.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл 21 хувиар өсөж 967 мянган тоннд хүрсэн байна. Үүнд Оюутолгойн зэсийн баяжмал үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс буурсан хэвээр байна.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар буурсан бол цар тахлын өмнөх үеэс 67 хувиар өслөө. Үнийн индексийг бүрэлдэхүүнээр харвал:

Үнэ өссөн:

- Хүнсний бүтээгдэхүүн 5.2 хувиар,
- Ундаа, согтууруулах ундаа 8.8 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 8.1 хувиар тус тус өссөн бол

Үнэ буурсан:

- Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийнх 0.8 хувиар
- Газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6 хувиар буурав.



Дотоод эдийн засгийн идэвхжил сайн, өсөлтийг тэтгэж байна.



- Эрэлтээс тооцсон ДНБ 2024 оны эхний хагаст 5.7 хувиар өслөө.
- Өсөлтөд эцсийн хэрэглээ 21.5 нэгж хувийн, хөрөнгийн хуримтлал 6.2 нэгж хувийн тус тус эерэг нөлөө, цэвэр экспорт 21.9 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв.

- Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалинг нэмсэнгэй холбоотойгоор төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 46.9 хувиар өсөж, нийт эрэлтийг дэмжиж байна.
- Өрхийн бодит орлого 17.3 хувиар сайжирснаар нийт өрхийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар нэмэгдэв.


- Үндсэн хөрөнгийн хуримтлал өмнөх оны түвшинд байна.
- Машин тоног төхөөрөмж 16.8 нэгж хувиар, орон сууцны бус барилга байгууламж 6.9 нэгж хувиар, окууны өмч 2.5 нэгж хувиар үндсэн хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлсэн бол биологийн өсөж үрждэг хөрөнгө 25.6 нэгж хувиар бууруулсан байна.

- Үйлчилгээний экспортын орлого өмнөх оны мөн үеэс багасаж, нүүрс, зэсийн баяжмалын үнийн бууралтаас шалтгаалан бараа, үйлчилгээний экспорт 2024 оны хагасад өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар буурав.
- Бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өсөв. Үүнд барааны импорт 29.4 хувиар, үйлчилгээний импорт 10.4 хувиар өссөн байна.




2024 оны эхний 8 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 18.1 тэрбум ам.доллар, тэнцэл 3.1 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Экспорт 2024 оны эхний 8 сард 10,625 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 6 хувиар өслөө.
- Нийт экспортын 93 хувийг уул уурхай бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 59 хувийг бүрдүүлж байна.
- Нүүрсний экспортын орлого 6,126 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өслөө.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 1,971 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 585 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 398 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 28.2 хувиар өслөө.
- 2024 оны эхний 8 сард импорт 7,501 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өссөн байна.
- Нийт импортын 18.6 хувийг тоног төхөөрөмж, 17.3 хувийг нефть, 9.1 хувийг автомашин эзэлж байна.
- Тоног төхөөрөмжийн импорт 1,393 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 34.2 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,300 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 684 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 51.3 хувиар өслөө.



2024 оны эхний 8 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 93 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(саятонн)



- Нүүрсний экспорт 2024 эхний 8 сард 55.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар өслөө.
- Гашуунсүхэйт боомтоор 27.5 сая тонц, Шивээхүрэн боомтоор 16.5 сая тонц, Ханги боомтоор 1.8 сая тонц, бусад боомтуудаар 9.6 сая тонн нүүрс тус тус экспортолсон байна.

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(тонн)



- Зэсийн баяжмалын экспорт 2024 эхний 8 сард 1,041 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өслөө.
- Гашуунсүхэйт (Оюу-Толгой) боомтоор 635 мянган тонц, Замын-Үүд (Эрдэнэт) боомтоор 406 мянган тонн зэсийн баяжмал тус тус экспортолсон байна.

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян тонн)



- Төмрийн хүдрийн экспорт 2024 эхний 8 сард 4,866 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар өслөө.
- Замын-Үүд боомтоор 4,398 мянган тонц, Бургастай боомтоор 409 мянган тонц, бусад боомтуудаар 59 мянган тонн төмрийн хүдэр тус тус экспортолсон байна.

ГАЗРЫН ТОС

(мян баррель)




- Газрын тосны экспорт 2024 оны эхний 8 сард 2,766 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 2,535 мянган баррель, Замын-Үүд боомтоор 231 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.




2024 оны эхний 8 сарын байдлаар сарын голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ (мянган \$)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

АРЬС ШИР (мянган \$)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООЛУУР (мянган \$)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС (мянган \$)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Малын махны экспорт 2024 оны эхний 8 сард 90,798 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 49 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багассан байна.
- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 8 сард 2,005 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 40 хувиар буурлаа.
- Ноолуурын экспорт 2024 оны эхний 8 сард 244,207 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар өслөө.
- Ноосны экспорт 2024 оны эхний 8 сард 3,480 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС


(\$/тонн, Сингапурын бирждэж Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС


(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын кокожих нүүрсний 2024 оны эхний 8 сарын дундаж үнэ 244 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3 хувиар буурсан байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны эхний 8 сарын дунджаар 9,118 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.


- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны эхний 8 сарын дундаж үнэ 114 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурсан байна.

- Брент газрын тосны 2024 оны эхний 8 сарын дундаж үнэ 80 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 7 хувиар өслөө.



2024 оны эхний 8 сарын байдлаар УУББ-ээр нийт 32 сая тонн нүүрс болон 2.1 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 5.4 мянган тонн зэсийн баяжмал, 12.2 мянган тонн жоншны баяжмалыг арилжаалаад байна.


НҮҮРСНИЙ АРИЛЖАА (сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 8 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 32 сая тонн нүүрс арилжиж, 4.1 тэрбум ам.долларын орлого олжээ
- 2024 оны 8 дугаар сарын байдлаар 2024 онд 17 сая тонн нүүрс арилжиж, 2.0 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 8 дугаар сард 0.9 сая тонн нүүрс борлууллаа.


НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 8 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 90 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 92 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 8 дугаар сард хэлцлийн доод үнэ 53 ам.доллар, дээд үнэ 162 ам.долларт хүрэв.


ТӨМРИЙН АРИЛЖАА (мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 8 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 2.1 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 159.3 сая ам.долларын орлого олжээ
- 2024 оны 8 дугаар сарын байдлаар 2024 онд 1.4 сая тонн төмрийг арилжаалж, 102.4 сая ам.долларын орлого олжээ.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)






Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- Төмрийн хүдэр болон баяжмалын 8 дугаар сарын дуудах дундаж үнэ 64 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 69 ам.доллар болж өсөв.
- Төмрийн төрлөөс хамааран 8 дугаар сард хэлцлийн доод үнэ 58 ам.доллар, дээд үнэ 73 ам.долларт хүрэв.



Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 7 сард 136 сая ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын улсын нөөц 2024 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 4.7 тэрбум ам.долларт хүрлээ. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 8 дугаар сарын эцэст оны эхнээс 30 төгрөгөөр чангарсан байна.



- Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 7 сард 136 сая ам.долларын алдагдалтай гарч, тэнцэл өмнөх оны мөн үеэс 589 сая ам.доллараар муудлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.9 тэрбум ам.доллараар нэмэгдсэн ч импортын өсөлт 1.5 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс алдагдалтай гарлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны эхний 7 сард 1.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 607 сая ам.доллараар өссөн байна.

- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 8 дугаар сарын эцэст 4,704 сая ам.доллар болж, өмнөх сараас 33 сая ам.доллараар буурч, өмнөх оны мөн үеэс 0.8 тэрбум ам.доллараар буюу 19.6 хувиар өслөө.

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 8 дугаар сард өдөрт дунджаар 0.01 төгрөгөөр суларснаар сарын эцэст 3,381 болж, оны эхнээс 30 төгрөгөөр буюу 0.9 хувиар чангарлаа.

- Төв банк 2024 оны 8 дугаар сард нийт 555 сая ам.долларыг, 2024 оны эхний 8 сард нийт 4,150 сая ам.долларыг тус тус зах зээлд нийлүүлээ.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 54.2 хувиар буюу 1,459 сая ам.доллараар өндөр дүн боллоо.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гаргах урсгалыг хассан дүн



Инфляц 2024 оны 8 дугаар сард 6.5 хувьд хүрч, өмнөх сараас 1.0 нэгж хувиар өслөө. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

САРЫН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

СУУРЬ ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 6.5 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.5 нэгж хувь (38.6%)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 4.0 нэгж хувь буюу 61.4 хувийг эзэлж байна.

- 2024 оны 8 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээ 18.6 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ. Харин хүнсний барааны үнэ өмнөх сараас 2.3 хувиар буурсан байна.

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 8 дугаар сард суурь инфляц 6.3 хувь гарч, нийт инфляцын 4.2 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 2 сар өслөө.


- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 8 дугаар сард жилийн инфляцын 15 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ 4,168 ам.доллар байгаа нь импортын инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна. Хүнсний үнийн индекс 2024 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурлаа.

ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ


(хувь)



- Хүнсний инфляц 2024 оны 8 дугаар сард 7.3 хувь болж, нийт инфляцын 2.1 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хүнсний бус инфляц 5.9 хувь болж, нийт инфляцын 4.4 нэгж хувийг бүрдүүллээ.

ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ


(хувь)



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 8 дугаар сард дунджаар 3,380 төгрөг болж, өмнөх сараас өөрчлөгдөөгүй байна.
- Валютын ханш өөрчлөгдөөгүй хэдий ч импортын бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх сараас 0.6 хувиар өсжээ.

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ

(1000\$/40 фут контейнер)



- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис/Суэцийн суваг үүсээд буй халдлагаас үүдэлтэйгээр өмнөх оны мөн үеэс 167 хувиар өсөж, 2024 оны 9 дүгээр сарын 12-ны байдлаар 40 фут контейнер 4,168 ам.доллар болсон байна.
- Энэ нь 2019 оны дундаж үе (цар тахлын өмнөх)-ээс 193 хувиар өндөр үзүүлэлт юм.
- Чингэлэг тээврийн үнэ өндөр хэвээр байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС



(хувь)



- НҮБ-ийн ХХААБ-аас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс нь хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- 2024 оны 8 дугаар сард хүнсний үнийн индекс 120.7 болж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурчээ.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээрх элсэн чихэр, мах, үр тарианы үнэ буурсан бол ургамлын тос, сүүн бүтээгдэхүүний үнэ өссөн байна.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 8 дугаар сарын байдлаар 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд цалин, хөлс, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ өссөн нь голлон нөлөөллөө.




- Нэгдсэн төсөв 2024 оны 8 дугаар сард 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 245.9 тэрбум төгрөг буюу 13.5 хувиар буурсан байна.
- Орлого 2024 оны 8 дугаар сард 19.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.6 их наяд төгрөг буюу 30.4 хувиар нэмэгдсэн байна.
- Дээрх өсөлтөд орлогын албан татвар 2.2 их наяд төгрөг буюу 57.3 хувиар, НӨАТ 823.7 тэрбум төгрөг буюу 28.1 хувиар, нийгмийн даатгалын орлого 474.1 тэрбум төгрөг буюу 19.8 хувиар, АМНАТ 489.9 тэрбум төгрөг буюу 16.9 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.
- Зарлага 2024 оны 8 дугаар сард 17.3 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 4.5 их наяд төгрөг буюу 35.4 хувиар нэмэгдсэн байна.
- 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар, алслагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалинг 20-40 хувиар нэмэгдүүлээд байна. Цалин хөлсний зардал 2024 оны 8 дугаар сарын байдлаар 3.3 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2.0 их наяд төгрөг буюу 2.4 дахин нэмэгдсэн байна.
- Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 30.2 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д харьцуулсан харьцаа 38 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.




Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны жилийн өсөлт 27.3 хувиар өсөж, 41.6 их наяд төгрөгт хүрлээ. Төгрөгийн харилцах, хадгаламж өсөлттэй байсан бөгөөд гадаад валютын харилцах, хадгаламж буурлаа. Зээлийн хүү 8 дугаар сард өмнөх сараас 0.2 нэгж хувиар нэмэгдэж, 17.0 хувьд хүрлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж Монголбанк

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж Монголбанк

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж Монголбанк

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 8 дугаар сарын эцэст 41.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 27.3 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 17.6 нэгж хувь, төгрөгийн харилцах 11.8 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.4 нэгж хувь, гадаад валютын харилцах -0.4 нэгж хувь, гадаад валютын хадгаламж -2.0 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.





- Нийт хадгаламж 24.7 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 20.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар, өмнөх сараас 1.0 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар, өмнөх сараас 0.7 хувиар тус тус буурлаа.

- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2024 оны 8 дугаар сарын эцэст 34.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 33.6 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурсан байна.

- Банкнуудын зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 8 дугаар сард 17.0 хувь болж, өмнөх сараас 0.2 нэгж хувь, өмнөх оны мөн 0.6 нэгж хувиар буурлаа.
- Банкнуудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 8 дугаар сард 11.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өслөө.



Цар тахлын нөлөөгөөр буураад байсан хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр сэргэж цар тахлын өмнөх түвшинг давлаа.



- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 68 мянгаар нэмэгдэж 1,347.1 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 184.9 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 2 дугаар улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 44.1 мянгаар нэмэгдсэн бол эмэгтэй ажилчид өмнөх оны мөн үеэс 23.9 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

- Ажилчдын тооны өсөлтөд худалдаа, үйлчилгээ ба бусад, тээвэр, боловсруулах, уул уурхай, барилгын салбарын ажилчид нэмэгдсэн нь эергээр нөлөөлсөн байна.
- Харин өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн салбарын ажилчид мөн ус, цахилгааны салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.


- Ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар, цар тахлын өмнөх үеэс 1.2 нэгж хувиар өслөө.
- Харин ажилгүй иргэдийн тоо 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 6.1 мянган хүнээр өсөж 82.3 мянгад хүрсэн байна.
- Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өсөж 5.8 хувьд хүрчээ.

- Дундаж цалингийн хэмжээ 2024 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өсөж 2 сая 465 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын медиан цалин 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 41.2 хувиар өсөж 2 сая 27 мянган төгрөг болов. Энэ нь дундаж цалингаас 438 мянган төгрөгөөр бага байна.
- Салбараар авч үзвэл уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж улсын дунджаас 2 дахин өндөр байна.




Цалингийн өсөлт хөдөлмөр эрхлэлт болон өрхийн орлогод эерэг нөлөө үзүүлж байна. Орлого багатай, цалингийн орлогогүй иргэдийн бодит орлого буурах эрсдэлтэй байна.


ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ (хувь)




ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ (хувь)



ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО (сая төгрөг)



ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО (сая төгрөг)



- Өрхийн бодит орлого 17.3 хувиар сайжирлаа.
- Өрхийн орлого нэрлэсэн дүнгээр 2.5 сая төгрөг болж өсөхөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 371 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

- Өрхийн орлогын 57 орчим хувийг цалингийн орлого бүрдүүлж байна.
- Цалингийн орлого цар тахлын өмнөх жилүүдэд өрхийн орлогын 54 орчим хувийг, цар тахлын үеэр халамж, тэтгэмжийн орлого нэмэгдсэний нөлөөгөөр 48 орчим хувь болж буурч байв.


- Нийт өрхийн 36.5 хувийг 1,6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүд бүрдүүлж байгаа ба тэдгээрийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр 952 мянган төгрөг байна.
- Харин 1,6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3,162 мянган төгрөг буюу 1,6 саяас бага орлоготой өрхүүдийнхээс даруй 3.3 дахин өндөр байна.

- Орлогын өсөлт нийслэлд эрчимтэй, хөдөө орон нутагт удаашралтай, орлогын тэгш бус байдал нэмэгдэж байна.
- Малчдын орлогын 50 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн орлого 10.9 хувиар буурсан нь хөдөөгийн өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.




ОХУ-ын Төв банк мөнгөний бодлогын хүүг өмнөх сард 2 нэгж хувиар өсгөж, 18 хувь болгосон нь сүүлийн 2 жилийн хамгийн өндөр үзүүлэлт хэвээр байна. Инфляцын түвшин өмнөх оны мөн үеэс 3.9 нэгж хувиар өсөж, 9.1 хувьд хүрлээ.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ
(хувь)




- Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 4.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурлаа.
- ОХУ-ын цэргийн армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн зардал тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой тэлэлттэй байсан эдийн засгийн өсөлт саарч, 2023 оны эхний улирлаас хойш доод үзүүлэлтэд хүрлээ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(тэрбум ам.доллар)




- Экспорт 2024 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 3.9 хувь, өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар тус тус өслөө.
- Экспортын өсөлтийг газрын тос, байгалийн хийн үнийн өсөлт голчлон дэмжсэн байна.
- Импорт 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар буурсан байна.
- Импортын бууралтад рублийн ханш суларч, логистикийн хүндрэл үүссэн нөхцөл байдал гол нөлөөлөл үзүүлээ.

ИНФЛЯЦ
(хувь)



- Инфляцын түвшин 2024 оны 8 дугаар сард 9.1 хувь, 2023 оны 12 дугаар сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт 9.1 хувийг хадгалсан хэвээр байна.
- ОХУ-ын Төв банк өмнөх сард мөнгөний бодлогын хүүг инфляц зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байгаа тул 2 нэгж хувиар өсгөж, 18 хувь болгох шийдвэр гаргасан.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (НЭГЖ)




- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2024 оны 8 дугаар сард 52.1 болж, өмнөх сарын үзүүлэлтээс 1.5 нэгжээр буурч, агшлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт өмнөх сараас 1.4 нэгж хувиар өсөж, 3.3 хувийн тэлэлттэй байлаа.



2024 оны 8 дугаар сард аж үйлдвэрийн гарц, жижиглэнгийн худалдаа, импортын өсөлтийн хурд саарсан бол экспортын өсөлт нэмэгдлээ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(хувь)




Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Экспортын өсөлт 2024 оны 8 дугаар сард 8.7 хувь болж, өмнөх сараас 1.7 нэгж хувиар эрчимжлээ.
- Импортын өсөлт 2024 оны 8 дугаар сард 0.5 хувь болж, өмнөх сараас 6.7 нэгж хувиар саарлаа.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ

(хувь)




Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2024 оны 8 дугаар сард 4.5 хувь болж, өмнөх сараас 0.6 нэгж хувиар саарсан бол жижиглэн худалдааны өсөлт өмнөх сараас 0.6 нэгж хувиар буурч, 2.1 хувьд хүрлээ.

ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- Хэрэглээний үнийн индексийн өсөлт 2024 оны 8 дугаар сард 0.6 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар өслөө.
- Харин үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2024 оны 8 дугаар сард өмнөх сараас 1.0 нэгж хувиар буурч -1.8 хувьтай гарлаа.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 8 дугаар сард 49.1 болж, 4 сар дараалан тэлэлтийг илтгэх босго утга 50-аас бага гарав.
- Харин аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас мөн өмнөх сараас буурсан ч босго утга 50-аас өндөр хэвээр байна.

Тус индекс нь богино хугацааны идэвхжлийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ